

## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

1. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь Дулааны сүлжээний ДХ-48 цэгээс Толгойтын гэр хорооллын дахин төлөвлөлтийг хангах 2Ф400 мм-ийн 4.2 км дулааны шугамын ажлын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ НХААГ-20/0125 дугаартай болно.

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараах мэдээллийг ирүүлнэ. Үүнд:

3.1 Улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн өнгөт хуулбар

3.2 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт

3.3 Харьяа дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тухай тодорхойлолт

3.4 Захиргааны хэргийн шүүхийн тодорхойлолт */Энэхүү тодорхойлолтод Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалтын талаар тусгасан байна./*

3.5 Одоогийн ба сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээлэл: */Шүүхийн ерөнхий зөвлөлийн төрөлжсөн архивын тодорхойлолт/*

Дээрх тодорхойлолтыг тендер зарлагдсан өдрөөс хойш авсан байх ба тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна

3.6 Хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн өргүй тухай харилцагч банкны тодорхойлолтыг улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан банк тус бүрээс ирүүлнэ.

3.7 Татварын ерөнхий газрын [www.e-tax.mta.mn](http://www.e-tax.mta.mn) сайтыг ашиглан цахим тодорхойлолтыг ирүүлэх ба ингэхдээ хуудсын доод хэсэгт байрлах тоо, тэмдэгт орсон 36 оронтой нууц дугаарыг гаргацтай байхаар ирүүлнэ. Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар хураамж, төлбөрөө төлсөн байна. Тодорхойлолт нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна.

3.8 Ижил төстэй ажлыг хамгийн багадаа нэг удаа гүйцэтгэсэн байвал зохих хугацаа: Төсөвт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ажил гүйцэтгэсэн байна. Сүүлийн 2 жил ( 2018, 2019 он) гүйцэтгэсэн ажлын гэрээ, акт, захиалагчийн тодорхойлолтыг хавсаргана.

3.9 Борлуулалтын хэмжээ: Сүүлчийн 2 жил /2018, 2019 он/-ийн борлуулалтын орлогын дундаж нь төсөвт өртгийн 50%-иас багагүй байна.

3.10 Голлох болон инженер техникийн ажилтнуудын дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлнэ.

- Дулааны инженер-1 /мэргэжлээрээ 3-аас дээш жил ажилласан байх/,
- Зураг төслийн инженер-1 /мэргэжлээрээ 1-ээс дээш жил ажилласан байх/,
- Мэргэшсэн төсөвчин-1 эсвэл дээрх инженерүүдийн аль нэг нь мэргэшсэн төсөвчин байх

3.11 Тусгай зөвшөөрлийн хуулбарыг эхээс баталгаажуулж ирүүлэх

3.12 **Зураг төсөл боловсруулах байгууллага нь:**

**Барилга, хот байгуулалтын яам**

**1.3.1.** Дулааны шугам гол сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг эсвэл

**3Т-3.5** Дулааны гол (магистраль) шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг

**Эрчим хүчний яам**

**3.9.9.** 0.7-40.0 кгх/см<sup>2</sup> даралттай шугам, хоолой, ЦТП-ны техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах эсвэл

**3.9.10** 0.7-40.0 кгх/см<sup>2</sup> болон түүнээс дээш даралттай шугам, хоолой, ЦТП-ны техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах

4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 10:00 цаг хүртэл авах бөгөөд Цахим Худалдан авах систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээр мэдүүлгээ 2020 оны 05 дугаар сарын 27–ны өдрийн 10:10 цагийн дотор ирүүлнэ үү.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу-15,  
Нийслэлийн Засаг захиргааны IV байр, 10 дугаар давхар,  
Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар,  
Утас: 75757807

Цахим хаяг: [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [www.ub-procurement.mn](http://www.ub-procurement.mn)